

**Өлгий сумын ЗДТГ-ын 01-р сарын 04-с эхлэн 7 хоногт
хийсэн ажлын мэдээлэл**

2019-01-10

- 019 оны сумын Хөгжил индексийг маягтын дагуу гаргав.
- 2019 онд Өлгий суманд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөөний төсөл бэлтгэв.
- Аймгийн ЗДТГазарт өгөх ёстой жилийн эцсийн тайлан мэдээнүүдийн дутууг гаргаж хүргүүлэв.
- Өлгий сумаас үерт өртсөн зорилттой бүлгийн айл өрхүүдэд мөнгөн болон нийгэм сэтгэлзүйн тусламж үзүүлэх төслийн талаар ТББ-тай хамтран зохих маягтын дагуу судалгаа хийсэн.
- Тамхи худалдах тусгай зөвшөөрөлгүй улмаас хураагдаж манайд шилжүүлсэн нэр бүхий тамхийг бөөний үнээр худалдаж үнийг орон нутгийн татварын дансанд оруулсан болно.
- Шинээр баригдаж ашиглалтанд орсон “Алмалы” зочид буудлын барилга объектын дүгнэлт гаргаж, цаашид үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зохих хууль журмын дагуу олгосон.
- Худалдаа үйлчилгээний цех салбаруудаас ИТХ-ын тогтоолыг үндэслэн хог хаягдлын хураамжийг авч ажиллаж байна.
- 9,3-р багийн иргэдийн гомдлын дагуу муу усыг асгасантай холбоотой мэдэгдэх хуудас тарааж арга хэмжээ авч ажиллаж байна.
- Өлгий сумын бүх цэцэрлэгүүдийн хүүхдийн ирцийн тоо авч, судалгааг гаргаж, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.
- Хүүхдийн 3-р цэцэрлэгийн хүсэлтийн дагуу шалгалт хийж дээврээс унаж байгаа шаврын дагуу МХГазартай хамтарч ажиллав.
- Хүүхэд харах үйлчилгээ явуулах иргэдийн судалгааг авч хамтарч ажиллаж байна.
- Дэлхийн зөн Монгол ОУБайгууллагаас зохион байгуулсан Сургалтанд Багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд оролцсон.
- 2,12 дугаар багт эзэнгүй нохой устгах ажлыг зохион байгуулсан.
- Цэргийн үүрэгтний судалгааг гаргаж байна.
- Японы хүүхдийн ивээх сангаас үерт өртсөн багийн хүүхдүүдэд үзүүлэх тусламжийн судалгааг нягтлан авч гаргаж байна.
- Багийн засаг дарга, нийгмийн ажилтнуудад Улсын бүртгэлийн шинэчилсэн хуулийн талаар мэдээлэл хийлгэсэн.
- Бүх багуудын 16нас хүрсэн хүүхдүүдийн шинээр цахим авах 25,45 насны сунгалтын судалгааг гаргаж Өлгий сумын Улсын бүртгэгч нарт гаргаж өгөв.
- Багийн Иргэдэд бүх төрийн үйлчилгээг үзүүлж байна.

ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ